



ШУТИС-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН
СУРГУУЛЬ, ТӨВИЙН ЗАХИРЛУУДАД

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛЬ**

Бага тойруу 34, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191
Утас: 32 51 09, 32 47 09, Факс: (976-11) 32 41 21,
Цахим шуудан: administration@must.edu.mn,
Цахим хуудас: www.must.edu.mn

2022.10.28 № 329

танай _____-ны № _____-т

Сургалт, судалгааны сарын
ажил зохион байгуулах тухай

“ШУТИС-д магистр, докторын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам”-ын 9, 10, 11, 12 дугаар зүйлийг тус тус үндэслэн, 2022/2023 оны хичээлийн жилийн сургалтын нэгдсэн хуанлийн дагуу “Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ыг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 26-ны өдөр хүртэл ШУТИС-ийн бүх бүрэлдэхүүн сургууль, төвийн хүрээнд удирдамжийн дагуу зохион байгуулна.

Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах комиссыг бүрэлдэхүүн сургууль, төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нар удирдан, эрдэм шинжилгээний болон сургалтын албаны холбогдох ажилтан, салбарын профессор нарын оролцоотойгоор гүйцэтгэх бөгөөд бүрэлдэхүүн сургууль, төвийн захирлын тушаалаар томилон ажиллуулна.

Сарын ажлыг зохион байгуулах комисс нь магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын хүрсэн түвшинг нэгтгэн дүгнэсэн тайланг Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрийн хамт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Эрдэм шинжилгээ, инновацийн газарт ирүүлэхийг мэдэгдье.

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗРЫН ДАРГА  Ж.АРСЛАН



367061336

2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
329 тоот албан бичгийн хавсралт



“МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТҮВШИН ТОГТООХ САРЫН АЖИЛ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2022.10.27

Улаанбаатар хот

Энэхүү удирдамжийн үндсэн зорилго нь Ректорын 2011 оны А-63 тоот тушаалаар баталсан “ШУТИС-д магистр, доктор (Ph.D)-ын сургалт явуулах, зэрэг хамгаалуулахад баримтлах журам”-ын 9, 10, 11, 12 дугаар заалтуудыг үндэслэн магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангаж, зохицуулахад оршино.

Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Магистрант, докторант нарын сурах, сургах үйл ажиллагааг бодитой үнэлэх, судалгааны ажлын удирдагч болон зөвлөхтэй хамтарч ажилласан байдал, туршилт судалгааны ажил нь тодорхой үе шатанд хийгдэж зохих түвшинд хүрсэн эсэхийг тогтоож үнэлэлт, дүгнэлт өгөх;
2. Cloudunimis, Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем, E Mongolia системд магистрант, докторантын мэдээллийг бүрэн орсон эсэхийг хянан магадлах;
3. Бүрэлдэхүүн сургууль, төвийн төгсөх магистрант нараас авах гадаад хэлний нэгдсэн шалгалтыг зохион байгуулах;
4. Бүрэлдэхүүн сургууль, төвийн докторант нараас мэргэжлийн нэгдсэн шалгалт авч, сургалт дүүргэсэн гэрчилгээ олгоход шаардлагатай материалуудыг бүрдүүлж, ЭШИГ-т ирүүлэх;
5. Бүрэлдэхүүн сургууль, төвийн магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулсан талаарх тайланг Эрдэм шинжилгээ, инновацын газарт tsoyun@must.edu.mn хаягаар 2022 оны 12 дугаар сарын 10-ны дотор цахимаар ирүүлнэ.

НЭГ. МАГИСТРАНТ, ДОКТОРАНТЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ АЖЛЫН ТҮВШИН ТОГТООХ САРЫН АЖИЛ”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

“Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ын хүрээнд магистрант, докторант нарыг бүрэн хамруулах ажлыг үр өгөөжтэй зохион байгуулахад дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

1. ШУТИС-ийн магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлыг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг дуустал бүрэлдэхүүн сургууль, төв дээр зохион байгуулна.
2. Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг бүрэлдэхүүн сургууль, төвийн захирлын тушаалаар томилон ажиллуулна.
3. Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлын явцад бүрэлдэхүүн сургууль, төвийн захирал, ЭНБДарга нар биечлэн хяналт тавьж ажиллана.
4. Мэргэжлийн салбарт харьяалагдах магистрант, докторант нэг бүрийн сургалт судалгааны ажлын үр дүн болон хүрсэн түвшинг суралцагч нэг бүрээр гаргаж, удирдагч, зөвлөх комиссуудад танилцуулах ба уг үйл ажиллагаанд магистрант, докторант нар өөрийн биеэр оролцоно.



ХОЁР. МАГИСТРАНТААС ГАДААД ХЭЛНИЙ НЭГДСЭН ШАЛГАЛТ АВАХ

2022-2023 оны хичээлийн жилийн “Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохих шаардлага хангасан магистрант нараас гадаад хэлний нэгдсэн шалгалт авах ажлыг их сургуулийн захирлын тушаалаар баталсан шалгалтын комисс зохион байгуулан явуулна.

Гадаад хэлний нэгдсэн шалгалтын комисс нь:

- Гадаад хэлний нэгдсэн шалгалтын материалын агуулга, тестийг боловсруулж, комиссын даргаар батлуулна.
- Гадаад хэлний нэгдсэн шалгалтын агуулга нь ШУТИС-ийн магистрантурын сургалтын гадаад хэлний хичээлүүдийн стандартын түвшинд боловсруулагдсан байх бөгөөд 74 буюу “С” үнэлгээнээс дээш үнэлгээтэй шалгагдсан тохиолдолд шалгалтанд тэнцсэнд тооцно.
- Магистрант нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад хэлний шалгалтын хүчин төгөлдөр гэрчилгээтэй бол уг гэрчилгээнд тавигдсан дүнг үндэслэн гадаад хэлний шалгалтыг дүйцүүлэн тооцох асуудлыг шалгалтын комисс шийдвэрлэнэ.
- Дүйцүүлж тооцох материалыг шалгалтын өмнө Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн албанд ирүүлэх бөгөөд шалгалт эхлэхээс өмнө шийдвэрлэсэн байна.
- Гадаад хэлний нэгдсэн шалгалтын комисс нь шалгалтын дүнг баталгаажуулан, шалгалт авсан тухай комиссын хурлын тэмдэглэл, холбогдох материалын хамт Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн албанд хүлээлгэн өгнө.

Магистрантаас гадаад хэлний нэгдсэн шалгалт авсан комиссын гишүүдийн ажилласан цагийн тооцоог ШУТИС-ийн холбогдох журмын дагуу тооцож олгоно.

Сургалт судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажлын хүрээнд гадаад хэлний нэгдсэн шалгалт өгөх магистрант дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Магистрант нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт хичээлийн гуравны хоёрыг судалж дүүргэсний дараа гадаад хэлний нэгдсэн шалгалт өгнө.
- Магистрант гадаад хэлний нэгдсэн шалгалт өгөх эсэхээ тухайн улирлын хичээл сонголтоор баталгаажуулсан байна.
- Шалгалтанд орох магистрант нь оюутны үнэмлэхтэй байна.

ГУРАВ. ДОКТОРАНТААС МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ШАЛГАЛТ АВАХ

“Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ын хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдөр зохих шаардлага хангасан докторантаас мэргэжлийн нэгдсэн шалгалт авах ажлыг зохион байгуулах бөгөөд шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг 2022 оны 11 дүгээр сарын 05-ны дотор ЭШИГ-т бичгээр ирүүлнэ.

Докторантурын сургалт явуулж буй бүрэлдэхүүн сургууль, төвийн мэргэжлийн нэгдсэн шалгалт авах комиссыг 3-аас доошгүй эрдэмтний бүрэлдхүүнтэйгээр (гадны байгууллагын нэг эрдэмтэнг оролцуулан) байгуулах бөгөөд ирүүлсэн саналыг үндэслэн их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

Мэргэжлийн нэгдсэн шалгалтанд орох докторант дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөөнд заагдсан нийт хичээлийг бүрэн судалж, сургалтыг дүүргэсэн байх;
- Онолын болон туршилт судалгааны ажлын 50-иас доошгүй хувийг гүйцэтгэсэн байх;
- Судалгааны ажлын үр дүнг харьяалах салбарын эрдэмтдийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн байна.

Мэргэжлийн нэгдсэн шалгалт өгсөн докторант нь 84 буюу “В” үнэлгээнээс дээш үнэлгээтэй шалгагдсан тохиолдолд шалгалтанд тэнцсэнд тооцно.



Докторантаас мэргэжлийн нэгдсэн шалгалт авсан комиссын гишүүдийн ажилласан цагийн тооцоог ШУТИС-ийн холбогдох журмын дагуу тооцож олгоно.

ДӨРӨВ. МАГИСТРАНТУР, ДОКТОРАНТУРЫН СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус сарын ажлын хүрээнд магистрантур, докторантурын сургалт явуулж буй бүрэлдэхүүн сургууль, төвийн мэргэжлийн салбарын профессорууд магистрант, докторант нарын судалгааны ажилтай танилцаж, сургалт судалгааны ажлын явцын талаар дараах ажлыг зохион байгуулна. Үүнд:

1. “Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2022 оны 10 дугаар сарын 31-ний дотор Эрдэм шинжилгээ, инновацын газарт tsoyun@must.edu.mn хаягаар ирүүлэх;
2. 2022-2023 оны хичээлийн жилд шинээр элссэн докторант нарын судалгааны ажлын сэдэв, удирдагч, зөвлөх комиссын бүрэлдэхүүнийг мэргэжлийн салбараар хэлэлцүүлж, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг баталгаажуулан, сарын ажлын тайлангийн хамт Эрдэм шинжилгээ, инновацын газарт tsoyun@must.edu.mn хаягаар ирүүлэх;
3. Cloudunimis бүртгэлийн мэдээллийн системд судалгааны ажлын сэдэв, удирдагч, зөвлөх комиссын бүрэлдэхүүнийг бүрэн оруулсаны дагуу их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулах тул бүртгэлийн мэдээллийг бүрэн оруулах;
4. Магистрантыг төлөвлөгөөний дагуу цаашид үргэлжлүүлэн сургах, сургалтаас чөлөөлөх, хасах, шилжүүлэх, жилийн чөлөө олгох эсэх талаар хэлэлцэж, холбогдох санал бүхий тэмдэглэлийг бүрэлдэхүүн сургууль, төвийн захирлын зөвлөлд танилцуулан шийдвэрийг Сургалтын хөтөлбөрийн албанд ирүүлэх;
5. Докторантыг төлөвлөгөөний дагуу цаашид үргэлжлүүлэн сургах, сургалтаас чөлөөлөх, хасах, шилжүүлэх, жилийн чөлөө олгох эсэх талаар хэлэлцэж, холбогдох санал бүхий тэмдэглэлийг бүрэлдэхүүн сургууль, төвийн захирлын зөвлөлд танилцуулан, шийдвэрийг Эрдэм шинжилгээ, инновацын газарт ирүүлэх бөгөөд их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулах;
6. “Магистрант, докторантын сургалт, судалгааны ажлын түвшин тогтоох сарын ажил”-ын хүрээнд хангалттай үнэлгээ авч, мэргэжлийн нэгдсэн шалгалтаа амжилттай өгсөн, сургалт дүүргэсэн гэрчилгээ авах болзол хангасан докторантын материалыг бүрдүүлэн, мэдээ, тайлангийн хамт Эрдэм шинжилгээ, инновацын газарт ирүүлнэ.
 - Докторантын сургалт дүүргэсэн гэрчилгээ авахыг хүссэн өргөдөл;
 - Салбарын хурлаар докторантын сургалт, судалгааны ажлын түвшинг хэлэлцүүлсэн хурлын шийдвэр;
 - Судалгааны ажлын удирдагч сургалт дүүргэсэн гэрчилгээ авах шаардлага хангасан эсэхэд тодорхойлолт гаргаж хавсаргах;
 - Оюутны дүнгийн хуудас;
 - Төлбөрийн тооцооны хуудас /сургалтын төлбөрийн тооцоогүйг баталгаажуулсан байна/.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦЫН ГАЗАР
СУРГАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН БҮРТГЭЛИЙН АЛБА